



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2023 оны 09 сарын 27 өдөр

Дугаар 478

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Дарханы дулааны сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 22 нэрийн, нийт 729,760,148.70 (долоон зуун хорин есөн сая долоон зуун жаран мянга нэг зуун дөчин найман төгрөг далан мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, “Дарханы дулааны сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Д.Батжаргал нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, сэлбэгээр ашиглах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Акталж данснаас хасах хөрөнгөөс төмрийн хаягдлыг ялган тоолж “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” төрийн өмчит хувьцаат компанид худалдах, орлогыг компанийн дансанд төвлөрүүлэх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4.Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132006037
24-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн
... дугаар тогтоолын хавсралт

"Дарханы дулааны сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, акталж данснаас хасах хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)
1	К85-К93 худгийн хоорондох дулааны магистрал шугмын өргөтгөл Ф273-823, 2м, ДЦС-Үйлдвэр	1965	м	2,284	203,976.54	465,821,225.39
2	К93-К94 худгийн хоорондох дулааны магистрал шугмын өргөтгөл Ф219, 2м, ДЦС-Үйлдвэр	1965	м	432	414,149.22	179,078,122.94
3	Үндсэн тосгон 47-р брак гадна худагас 53-р брак /Салбар шугам/К3211-К3212/	1965	м	168	44,697.35	7,509,154.89
4	Салбар шугам /К18.01-К18.22/	1965	м	112	35,165.27	3,938,510.13
5	Салбар шугам /К18.22-К18.23/	1965	м	52	35,341.47	3,958,244.27
6	Салбар шугам /К1823-К1824/	1965	м	154	81,445.79	4,235,181.17
7	Салбар шугам /К5102-К5103/	2014	м	140	152,117.45	23,426,087.23
8	Салбар шугам /К4806--К4807/	1965	м	156	30,347.86	4,248,700.84
9	Салбар шугам /К4807--К4808/	1965	м	62	58,785.22	8,229,930.55
10	Салбар шугам /К4808--К4809/	1965	м	20	47,414.00	7,396,584.15
11	Салбар шугам /К4809--К4810/	2000	м	40	28,156.38	4,392,395.14
12	Салбар шугам /ДХ11--ДХ27/	2000	м	31	47,152.56	3,866,510.00
13	Салбар шугам /ДХ11--ДХ27/	2000	м	31	49,383.20	5,037,086.00
14	Салбар шугам /ДХ26--ДХ27/	2000	м	88	31,893.47	5,613,251.00
15	Салбар шугам /ДХ26--ДХ27/	2000	м	44		
16	Салбар шугам /ДХ26--ДХ27/	2000	м	44		
17	Салбар шугам /ДХ25--ДХ26/	2000	м	58		
18	Салбар шугам /ДХ25--ДХ26/	2000	м	29		
19	Салбар шугам /ДХ25--ДХ26/	2000	м			
20	Салбар шугам /ДХ24--ДХ25/	2000	м			
21	Салбар шугам /ДХ24--ДХ25/	2000	м			
					25,941.08	3,009,165.00

22	Салбар шугам /ДХ24--ДХ25/	2000	м	29	3,974 (гурван мянга есөн зуун далан дөрөв)	1,285,966.86 (нэг сая хоёр зуун наян таван мянга есөн зуун жаран зургаан төгрөг наян зургаан мөнгө)	729,760,148.70 (долоон зуун хорин есөн сая долоон зуун жаран мянга нэг зуун дөчин найман төгрөг далан мөнгө)
Нийт дүн							